

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН “САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Тус хэлэлцээрийн төслийн хүрээнд 19 жилийн хугацаанд эргэн төлөх хугацаатай, эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй, 1 хувийн хүүтэй, 0.9 хувийн баталгааны шимтгэлтэйгээр 65 сая еврогийн зээл авах бөгөөд хүүгийн төлбөрт 12.8 сая евро төлнө. Хэлэлцээрийн хүрээнд улсын эмнэлгүүд болон Дуурь, бүжгийн эрдмийн театрын тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц тус төслүүд хэрэгжсэнээр хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан ямар шалгуур үзүүлэлтүүдэд нийцэх талаар болон хэлэлцээрээр хэрэгжүүлэхээр тусгасан төслүүдийг эрэмбэлсэн шалгуур үзүүлэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслүүдийн хэрэгцээ шаардлага, хуваарилалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат улсын эмнэлгүүдэд төсөл хэрэгжсэнээр эрүүл мэндийн салбарт гарах үр дүн, ач холбогдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан төслийн хүрээнд эх, хүүхэд, нярайн эндэгдэл бууруулах арга хэмжээний талаар болон Дуурь, бүжгийн эрдмийн театрын тоног төхөөрөмжийн шинэчлэлийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан бөгөөд хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 72.7 хувийн саналаар зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.ЗАЯАБАЛ**